

**ДЦС-3 ТӨХК
ДУЛААНЫ ГУРАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ**

**ТРДН –МАРКИЙН 40000КВА ТРАНСФОРМАТОР ТГ-5-Н ИХ ЗАСВАР ХИЙХ
АЖЛЫН ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ**

Төслийн нэр:

**ТРДН –МАРКИЙН 40000КВА ТРАНСФОРМАТОР ТГ-5-Н ИХ
ЗАСВАР ХИЙХ**

Төслийн дугаар:

ЗХА-06.2020

ДЦС-3

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Зарлах огноо: 2020-05-13

“ДЦС-3” ТӨХК нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос “ТРДН маркийн 40000кВа трансформатор ТГ-5-н их засвар хийх” тухай цахим үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг Төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим системээс үнэ төлбөргүй авч болно.

Үнийн саналыг **2020 оны 05-р сарын 20-ны өдрийн 10.00 цагаас** өмнө Төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим системээр илгээнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2020 оны 05-р сарын 20-ны өдрийн 10:30-д** цахим системээр нээнэ.

Дотоодын давуу эрх тооцох эсэх: тооцохгүй

Сонирхсон этгээд бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг 3-р хороо,
“Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн захиргаа, 2 давхар
Хангамжийн хэлтэс: Утас: 70111304, Факс: 344111.
Веб хуудас: www.tes3.energy.mn**

Хоёр. **ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА**

1. **Эрх бүхий тендерт оролцогч**
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
2. **Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
3. **Тендерийн иж бүрдэл**
 - 3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:
 - (а) Үнийн санал;
 - (б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
4. **Тендерийн үнэ**
 - 4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.
 - 4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.
 - 4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.
 - 4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.
5. **Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
 - 5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
6. **Алдааг залруулах**
 - 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:
 - (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;
 - (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;

- (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<ol style="list-style-type: none"> 1. Үнийн санал маягтын дагуу ирүүлэх 2. Сүүлийн 1 жил (2019 он)-ийн жилийн аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх. 3. Борлуулалтын орлого:Сүүлийн 1жил (2019 он) Төсөвт өртөгөөс дээш байх 4. Сүүлийн 1 жил(2019 он)-ийн ижил төстэй ажлын туршлагын мэдээлэл (Трансформаторын засварын ажил гүйцэтгэсэн гэрээ, гэрээ дүгнэсэн акт, захиалагчийн тодорхойлолт ирүүлэх) 5. Аж ахуйн нэгжийн болон НӨАТ-н гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар, 6. Компанийн товч танилцуулга, 7. Татварын албаны цахим тодорхойлолт ирүүлэх шаардлагагүй бөгөөд тендер нээсэн өдрийн байдлаар цахим системээс татан авч үнэлгээнд ашиглана (Өргүй байх) 8. Харьяалагдах нийгмийн даатгалын хэлтсийн тодорхойлолт. (Өргүй байх) 9. Харилцагч банкны хугацаа хэтэрсэн зээлийн өргүй тухай тодорхойлолт ирүүлэх 10. Сүүлийн 3 жилийн хугацаанд гэрээний үүргээ ноцтой зөрчсөн, авилгалын хэрэгт холбогдож байсан эсэх талаар захиргааны хэргийн шүүхийн лавлагаа ирүүлнэ. 11. Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүхийн төрөлжсөн архивын лавлагаа ирүүлнэ. 12. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын шийдвэр гүйцэтгэх албаны ер төлбөргүй талаар тодорхойлолт ирүүлнэ. 13. Ажиллах хүчний мэдээлэл <ul style="list-style-type: none"> • Ажлын удирдагч-Цахилгааны ХБ-ын мэргэшсэн инженер-1 • Монтер(АА-ны 5-р групптэй)-1 • Монтер(АА-ны 4-р групптэй)-2 • Монтер(АА-ны 3-р групптэй)-2 <p>Ажилтануудын 1-с доошгүй хүн оосорлогч дохиочины үнэмлэхтэй байх. Ажилтануудын иргэний үнэмлэх, мэргэжлийн диплом, үнэмлэх, сертификатуудыг нотариатаар баталгаажуулан ирүүлэх</p> 14. Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь, 15. Цахилгааны мэргэшсэн төсөвчинөөр баталгаажуулсан төсөв 16. Техник хэрэгслэл Дараах үндсэн тоног төхөөрөмжийг ажлыг гүйцэтгэх хугацаанд (өөрийн, түрээслэх, хөлслөн авах г.м.) бэлэн байлгах шаардлагатай. Үүнд: <ul style="list-style-type: none"> • Ачих, зөөх машин механизм • Засвар хийх тусгай түлхүүр, торцов, төхөөрөмжүүд • Өргөх зөөх тросс, таль, рым, скоб • Цахилгаан гагнуурын хэрэгсэлүүд-2 комплект, • Хийн гагнуурын хэрэгсэл 2 комплект • Хөдөлмөрийн аюулгүй байдлын хувцас, хамгаалах хэрэгсэлүүд хүн нэг бүрт • Цахилгаан огтлох, өнгөлөх, өрөмдөх төрөл бүрийн хэрэгсэлүүд <p>Техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн жагсаалтыг ирүүлэх</p> 17. Тусгай зөвшөөрөл Эрчим хүчний яамны <u>03.2.1 0.4-10 кВ-ын ЦДШ, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт, тохируулга, бусад дагалдах ажил үйлчилгээ.</u>

ТӨӨЗ 2.1	Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn Огноо: 2020 оны 05-р сарын 20-ны өдөр Цаг: 10 цаг 00 минут
ТӨӨЗ 2.1	Тендер нээлт хийх газар хугацаа нь: Байгууллагын хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг 3-р хороо, “Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн захиргаа, 2 давхар 215 тоот Огноо: 2020 оны 05-р сарын 20-ны өдөр Цаг: 10 цаг 30 минут
ТӨӨЗ 2.3	Долдугаар бүлгийн маягтуудаас гадна эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТӨӨЗ 1.1 д заасан тодорхойлолтуудыг нууцлалгүйгээр ирүүлнэ.
ТӨӨЗ 6.2	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: багцгүй

Дөрөв:ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

“ТРДН-40000кВа-н трансформаторт их засвар хийх” ажил гүйцэтгэхдээ тендерийн материалын 5-р бүлэгт заагдсан ажлын эзэлхүүнд тусгагдсан бүх ажлыг үзель зангилаа бүрд бүрэн хэмжээгээр чанартай гүйцэтгэнэ. Ажлын явцад ажлын эзэлхүүнээс нэмэгдэх хасагдах зүйл гарч болно. Гарсан нэмэгдэл ажлыг магадлашгүй ажлын зардлаар хийнэ. Магадлашгүй ажлын зардал болон НӨАТ - г гүйцэтгэгч төсөвтөө тусгаж өгнө. Захиалагч нэмэлт ажлын төсөв зардал гэж тусдаа гаргахгүй .

Их засварын ажлыг гүйцэтгэхдээ засварын технологиудыг чанд баримталж ажиллах, шаардлагатай үед ЗХА-ны мэргэжилтэнүүдтэй зөвлөлдөж тусгай технологи гаргаж түүний дагуу засварын ажил гүйцэтгэх ёстой. Дур мэдэн ямар нэг өөрчлөлт, технологи хэрэглэхгүй байх.

Захиалагч засварын технологийн мөрдөлт, засварын чанар, материал сэлбэг зарцуулалт, ажлын гүйцэтгэлд төслийн менежер болон захилагчийн мэргэжлийн инженер бусад мэргэжилтэнүүд хяналт тавьж ажиллана.

ГҮЙЦЭТГЭГЧИД ТАВИГДАХ ТЕНДЕРИЙН ШААРДЛАГА, ТЕНДЕРИЙН НӨХЦЛҮҮД

1.ТЕНДЕРИЙН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

1. Энэхүү засварын ажлыг 30 хоногт буюу 9-р сарын 05-нд бүрэн хэмжээгээр хийсэн байна.
2. Засварын ажлыг хийж гүйцэтгэхэд шаардагдах авто машин кран, хийц, эд ангиуд, тэдгээрийг үйлдвэрлэх, нийлүүлэх, техникийн зураг, техникийн детальчилсан зураг гаргах, зорлого хийх, матах, өрөмдөх, хуйлах ажлын хөлс, турших тохируулахад гарах зардал болон бусад зардлыг гүйцэтгэгч бүрэн хариуцах бөгөөд зардлуудыг сонгон шалгаруулалтын материалд тусгасан байвал зохино.
3. Тендерийн заавал биелүүлэх нөхцөл, тендерийн шаардлага, ХАБЭА-н шаардлагуудад шаардагдах хөрөнгийг гүйцэтгэгч хариуцахаар тусгах шаардлагатай.
4. Гүйцэтгэгч компани хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн байцаагч инженер томилон ажиллуулна. Засварын ажлын явцад ХАБЭА-н зөрчил доголдолгүй ажиллуулах ажил зохион байгуулах үүргийг гүйцэтгэгч байгууллагын удирдлага, ажлын нарыдаар үүрэг хүлээгчид шууд хариуцна.

2. ЗАСВАР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГАД ТАВИГДАХ ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ ЭРУУЛ АХУЙН ШААРДЛАГА

1. Засварт оролцох гүйцэтгэгч байгууллагын (туслан гүйцэтгэгч мөн хамаарна) ажиллагсад нь Эрчим хүчний үйлдвэрт мөрдөгдөж байгаа ТАД, ААД, ГАУСД, ХАБЭА хуулийн зохих мэдлэгтэй, ээлжит шалгалт өгсөн мэргэжлийн үнэмлэхтэй, оосорлогч дохиочноор ажиллах хүмүүс мэргэжлийн үнэмлэхтэй байна.
2. Тухайн ажлын байранд ажиллах хүмүүс шаардлагатай хамгаалах хэрэгсэл, ХАБЭА-н хувцасаар бүрэн хангагдсан, эрүүл мэндийн үзлэгт орсон,энэ ажилд эрүүл мэндээр тэнцэх хүмүүс байна.
3. Ажлын байрыг байнга эмх цэгцтэй , хог хаягдлыг тухай бүр нь зайлуулж, шат тавцангууд болон эд ангиудыг шуурхай ажиллагаанд /ашиглалтын ажилд/ саад болохооргүй чөлөөтэй байлгах үүрэг хүлээнэ.
4. Засварт оролцох гадны байгууллагын ажиллагсад нь “ДЦС-3” ТӨХК-ийн дотоод дүрэм журам, ХАБЭА-н талаар мөрдөгдөж байгаа дүрэм, журам эдгээрийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага, торгууль, шийтгэлийг мөн адил мөрдөж ажиллах үүрэгтэй.
5. Ажлын онцлогоос хамааруулж зарим нэг тоноглол, үзельд засвар хийхдээ тусгай шат тавцан барих, аюулгүйн зон татах, анхааруулах тэмдэг плакат өлгөх, шаарлагатай гэж үзвэл доош юм унахаас сэргийлсэн тор татах хүртэл ажил зохион байгуулахыг гүйцэтгэгч байгууллагын удирдлага, ажил удирдагч, ажил гүйцэтгэгч нар шууд хариуцна.
6. Ажлын байранд галын хэсгийн зөвшөөрөлгүй, галын нарядгүйгээр гагнуурын болон галын аюултай ажил гүйцэтгэх, ил гал түлэх, тамхи татахыг хориглоно.

Тав. ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ

**ТРДН-МАРКИЙН 40000 кВа-н ТРАНСФОРМАТОРЫН
ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН ЭЗЭЛХҮҮН / ТГ-5/**

№	Хийгдэх ажил	Хэмжих нэгж	Ажлын тоо хэмжээ
1	Бэлтгэл ажил: Трансформаторын их засварт шаардлагатай багаж хэрэгсэл, материал сэлбэг байр бэлдэх	ш	1
2	Трансформаторын холболтуудыг тайлж зөөхөд бэлдэх / Нийт 6ш /	ш	1
3	Трансформаторын дугуйг эргүүлж тууш зам дээр тавих	ш	1
4	Трансформаторыг зөөж засварын байранд авч ирэх / трактор ашиглах , захиалах 150м зам /	ш	1
5	Их засварын өмнөх хэмжилт туршилт хийх	ш	1
6	Трансформаторын тосыг юүлэх / Нийт 30тн /	ш	1
7	Трансформаторын гадна талын арматур тайлж авах, заглушка тавих / 34ш заглушка /	ш	1
8	Трансформаторын дугуйг эргүүлж турбин зааланд зееж оруулах	ш	1
9	Трансформаторын тосыг бүрэн юүлж трансформаторыг задлах, ороомгууд болон зірхэвчинд үзлэг засвар хийх	ш	1
10	Трансформаторын оруулгуудад их засвар хийх / Нийт 3 ком 110кВ-н оруулага /	ш	1
11	Трансформаторын бак болон тележканд их засвар хийх	ш	1
12	Трансформаторын радиаторуудад их засвар хийх Нийт 10ш	ш	1
13	Расширитель болон выхлопная трубад засвар хийх	ш	4
14	Термосифонный фильтруудэд их засвар хийх	ш	2
15	Обдувкийн хеделгүүрүүдэд их засвар хийх	ш	12
16	Трансформаторын маслаг хатаах цэвэрлэх	ш	1
17	Трансформаторын РПН-н контактор болон переключателийн их засвар болон хэмжилт тохируулга хийх	ш	1
18	Трансформаторыг угсрах, нягтруулгуудыг солих	ш	1
19	Трансформаторын тосыг хийх	ш	1
20	Трансформаторыг засварын байранд зееж авч ирэх	ш	1
21	Трансформаторын арматурыг угсрах	ш	1
22	Трансформаторын тосыг хийж бүх хэмжилт туршилтуудыг хийх	ш	1
23	Трансформаторыг зееж ажлын байранд нь авч ирэх	ш	1
24	Трансформаторын холболтуудыг холбож ажилд залгахад бэлэн болгох	ш	1
25	Трансформаторын гадаад өнгө үзэмжийг сайжруулах, угаах ,зүлгэх өнгөлөх, тосыг цэвэрлэх , будах	ш	2
26	Трансформаторыг ажилд залган комисст хүлээлгэн өгөх	ш	1

Зургаа. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

“ДЦС-3” ТӨХК-ын дарга Ч.Чинбат танаа

1. Бид, **[тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]**-ыг **[тендерийн үнийг тоогоор болон үсгээр]** төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.
5. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

Долоо. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. **Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх** 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ.
2. **Төслийн менежерийн шийдвэр** 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ.
3. **Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх** 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана.
4. **Аюулгүй байдал** 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.
4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ.
5. **Зааварчилгаа** 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй
6. **Маргааныг шийдвэрлэх** 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.
- Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ**
7. **Ажлын хөтөлбөр** 7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежер хүргүүлж батлуулна.
7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежер хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана.
8. **Зөрчил, гологдол илрүүлэх** 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй.
9. **Зөрчил, гологдол арилгах** 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа¹ дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.
9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг

¹ Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

- зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.
- 10. Зөрчил, гологдол арилгахгүй байх**
- 10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.

В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ

- 11. Үе шатны ажлын хуваарь**
- 11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарьт тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.
- 11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.
- 12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх**
- 12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.
- 13. Алданги**
- 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги² төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ

- 14. Ажил дуусгах**
- 14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.
- 15. Хүлээж авах**
- 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.
- 16. Эцсийн тооцоо**
- 16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ. Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно. Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.

² Алдангийг ихэвчлэн хоногт 0.05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

- 17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага**
- 17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.
- 17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.
- 18. Гэрээг цуцлах**
- 18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.
- 18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:
- (а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;
 - (б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;
 - (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;
 - (г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;
 - (д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.
- 18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.
- 19. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр**
- 19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.
- 19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.
- 20. Гүйцэтгэлээс чөлөөлөх**
- 20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд

зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

Найм. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

ГЕН 2.1	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: ТРДН маркийн 40000кВа трансформатор ТГ-5-н их засвар хийх ЗХА-06.2020
ГЕН 2.1	Ажил нь ТРДН маркийн 40000кВа трансформатор ТГ-5-н их засвар хийлгэх ажлаас бүрдэнэ. Ажлын талбай нь ДЦС-3 ТӨХК-ийн Цахилгаан цехийн ил хувиарлах байгууламж Т-5 трансформатораар тодорхойлогдсон болно.
ГЕН 3.1	Төслийн менежер нь: ЗХА-ны туршилт хамгаалалт / цахилгааны / инженер Э.Баттогтох
ГЕН 4.1	Ажил эхлэх өдөр 2020 оны 08-р сарын 05 Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр 2020 оны 09-р сарын 05
ГЕН 4.2	Гүйцэтгэгчийн ажиллагсад нь өөрийн компаний эмблем, лого, эсвэл таних тэмдэг бүхий Захиалагчийн ажиллагсдаас ялгарах ажлын хувцастай байх ба мэргэжлийн үнэмлэхээ биедээ авч явна.
ГЕН 4.2	Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхдээ Цахилгаан станц, дулааны шугам сүлжээний дулаан механикийн тоноглолын ашиглалтын үеийн аюулгүй ажиллагааны дүрэм болон Цахилгаан байгууламжийн ашиглалтын үед мөрдөх аюулгүй ажиллагааны дүрэм/ ААД/, Цахилгаан станц, шугам сүлжээний техник ашиглалтын дүрэм/ТАД/ ГАУСД, Уурын болон усан халаалтын зуухыг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм, Даралтат савыг төхөөрөмжлөх аюулгүй ашиглах дүрэм, Компаний дотоод журам болон Эрчим хүчний салбарт одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа дүрэм журам заавруудыг ягштал мөрдөнө.
ГЕН 4.2	Засварын ажлыг гүйцэтгэгч компани нь аливаа ажлыг гүйцэтгэхдээ мэргэжлийн зэрэг, категори, албан тушаал нь тохирох, аюулгүй ажиллагааны дүрмийн шаардлагад нийцсэн “нарядын хариуцлагатнууд”-ын нэрсийн жагсаалтыг захиалагчид ирүүлж батлуулах ба тэдгээр хариуцлагатнууд нь засварын ажлыг гүйцэтгэх явцад нарядын системийг чанд мөрдөнө
ГЕН 4.2	Гэрээт ажлыг гүйцэтгэхдээ хөдөлмөрийн аюулгүй байдлыг бүрэн хангуулах, галын аюулаас урдчилан сэргийлэх бүх талын арга хэмжээг авч ажиллах ба зөрчил гаргасан болон тавьсан шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд ажлыг зогсоох хүртэл арга хэмжээ авна
ГЕН 4.2	Цахилгааны схем, зөөврийн болон байнгын гэрэлтүүлгийг холбох, таслуулах, шилжүүлэх тохиолдолд Захиалагч талын шуурхай ажиллагааны хүмүүст захиалга өгч, мэргэжлийн хүнээр гүйцэтгүүлэх үүрэгтэй. Мөн станцын суурин өргөх, зөөх механизмаар үйлчлүүлэх, шаардлагатай хийц, бэлдэцийг Механик цехэд урьдчилан захиалга өгч гүйцэтгүүлнэ.
ГЕН 4.2	ХАБЭА, ААД, ТАД, станцын дотоод журам болон ЭХ-ий салбарт мөрдөгдөж байгаа дүрэм журмыг зөрчсөнөөс, түүнчлэн өөрсдийн буруугаас тоног төхөөрөмжийг гэмтээсэн, үйлдвэрлэлийн осол гаргасны улмаас учирсан хохирол, хариуцлагыг гүйцэтгэгч байгууллага бүрэн хариуцах үүрэгтэй
ГЕН 7.1	Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш 5 хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
ГЕН 7.2	Гүйцэтгэгч нь засвараас гарсан хог хаягдлыг тухай бүр нь зайлуулж байхын зэрэгцээ захиалагчийн төлөөлөгч, техникийн удирдлага болон байцаагч нарын тавьсан шаардлагыг бүрэн биелүүлж хариуг бичгээр буюу амаар цаг тухайд нь мэдэгдэж байх үүргийг хүлээнэ
ГЕН 9.1	Чанарын баталгаат хугацаа ашиглаж эхэлснээс 90 хоног байна.

ГЕН 13.1	Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн 0,3 хувь байна. ³ Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн 30 хувь байна.
ГЕН 17.1	Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг шахалт туршилтын актыг нэгж тоноглолын засвар дуусах бүр гаргаж өгнө. Гүйцэтгэлийн зургийг [огноо]-ны дотор гаргаж өгнө. Гүйцэтгэлийн зургийг, эсхүл ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд суутгах төлбөрийн хэмжээ [мөнгөн дүн] байна. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэсний дараа дараах бичиг баримтыг 4 % бүрдүүлнэ. Үүнд. 1. Ажил гүйцэтгэх гэрээ 2 . Анхны батлагдсан төсөв 3 . Ажлын гүйцэтгэл 4 . Ажлын гүйцэтгэл хүлээлцсэн комиссын акт 5 . Гэрээ дүгнэсэн протокол 6 . Материалын тайлан 7. Шахалт туршилтын акт 8.Тоноглолын эд ангиудын засварын өмнөх ба дараах фото зураг 9.Засвараас гарсан хог хаягдлыг зөвшөөрөгдсөн хогийн цэгт хаясан баримт 10 . Хуучин сэлбэг материал тушаасан бичиг
ГЕН 19.1	Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусаагүй ажлын [хувь]-иар тооцно.

³ Ажлыг хэсэг хэсгээр дуусгах болон хэсэг бүрт алданги хэрэглэх бол энд тусгана.

ГЭРЭЭНИЙ МАЯГТ⁴

ЗАХИАЛАГЧ	ГҮЙЦЭТГЭГЧ
БАТЛАВ “ДЦС-3” ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ	БАТЛАВ “.....” ХХК-ИЙН ЗАХИРАЛ
/	/

ТРДН –МАРКИЙН 40000КВА ТРАНСФОРМАТОР ТГ-5-Н ИХ ЗАСВАР ХИЙХ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2020 оны -р сарын . . .-ны өдөр №..... Улаанбаатар хот

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ.

Нэг талаас “ДЦС-3” ТӨХК–г төлөөлж Тэргүүн дэд захирал, ерөнхий инженер Л.Нямхүү /цаашид “захиалагч” гэх/, нөгөө талаас “.....” ХХК-ийг төлөөлж инженер /цаашид “гүйцэтгэгч” гэх/ нар нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29-р зүйлийн 29.1 дахь заалт, “ДЦС–3” ТӨХК-ийн Харьцуулалтын ажлын хэсгийн 20.... оны-р сарын-ны өдрийн хурлын тоот шийдвэр, Харьцуулалтын ажлын хэсгийн ЗХА-..... тоот зөвлөмж, 2020 оны Бизнес төлөвлөгөө, Удирдлагын шийдвэрийг үндэслэн харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

ГЭРЭЭНИЙ ЗОРИЛГО

“ТРДН-40000кВа-н трансформаторт их засвар хийх” ажлыг тендерийн баримт бичигт заасан шалгаруулалт, шаардлагад нийцүүлэн графикт хугацаанд чанартай, технологийн дагуу хийж гүйцэтгэн хүлээлгэж өгөх, захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтоох, төлбөр тооцоог гэрээнд заасан хугацаанд хийж гүйцэтгэхэд гэрээний зорилго оршино.

НЭГ. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. “ТРДН-40000кВа-н трансформаторт их засвар хийх” ажлыг 2020 оны 08-р сарын 05-наас 2020 оны 09 -р сарын 05 -ны хооронд багтаан хийж хүлээлгэн өгнө.

1.2. Гэрээт ажлын үнэ Харьцуулалтын ажлын хэсгийн тоот зөвлөмжийн дагуу НӨАТ болон бусад бүх зардлыг тооцоод /...../ төгрөг байна.

1.3. Гэрээт ажлын хөлсний 90%-ийг гэрээт ажлыг хүлээн авч, гэрээ дүгнэсэн акт батлагдсанаас хойш хуанлийн 30 хоногт багтаан шилжүүлнэ.

1.4. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- Бусад шаардлагатай баримт бичиг ;
- Үнийн санал
- Гэрээний тусгай нөхцөл;
- Гэрээний ерөнхий нөхцөл;
- Техникийн тодорхойлолт;
- Зураг;
- Гүйцэтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь ;
- Санхүүжилтийн хуваарь;
- Ажил гүйцэтгэх хуваарь.

⁴ Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

ХОЁР. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

2.1. Засварын ажлыг гэрээнд заасан хугацаанд хүлээн авч санхүүжилтийг гэрээ дүгнэсэн акт болон нэхэмжлэлийг үндэслэн хийж гүйцэтгэнэ

2.2. Гүйцэтгэсэн ажлыг хугацаанд комисс гарган хүлээн авна.

2.3. Баталгаат хугацаа хүлээлгэн өгснөөс хойш 3 сар буюу 2200 цаг ажилласан байна. Гэрээт ажлын баталгаат хугацаа дууссаны дараа баталгаат хугацааны 10%-г олгох хурлын тэмдэглэлийг үндэслэн гүйцэтгэгч талд шилжүүлнэ.

2.4. Баталгаат хугацаанд гүйцэтгэгчийн хийж гүйцэтгэсэн ажилтай холбоотой гэмтэл доголдол гарвал дахин үнэ төлбөргүй хийж гүйцэтгэхийг шаардах эрхтэй.

2.5. Захиалагч нь их засварын ажилд шаардагдах сэлбэг материалыг цаг хугацаанд нь олж нийлүүлэх үүрэгтэй.

ГУРАВ. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

3.1. Засварыг гэрээнд заасан хугацаанд технологийн дагуу чанартай хийж хүлээлгэн өгнө.

3.2. “ТРДН-40000кВа-н трансформаторт их засвар хийх” ажилтай холбогдолтой техникийн бичиг баримтыг бүрдүүлэх.

3.3. Засварын ажил нь чанарын шаардлага хангахгүй тохиолдолд гүйцэтгэгч хугацаа алдалгүй өөрийн хүчээр хийж өгөх ба гарсан бүх зардлыг хариуцна.

3.4. Засварын хугацаанд ХАБЭА-н болон бусад аюулгүй ажиллагааны бүх арга хэмжээг бүрэн хариуцаж ажиллана.

3.5. Засварын ажил гүйцэтгэхийн өмнө гүйцэтгэгчийн ажиллагчид үйлдвэрлэл, ажлын байрны өвөрмөц онцлог, осол гэмтлээс сэргийлж ажиллахтай холбогдсон урьдчилсан зааварчлагааг ДЦС-3 ТӨХК-н ХХ-ны байцаагч инженерүүдээс авч ажилд орно./ Мөн түүнчлэн галын байцаагчаас/

3.6. Гүүрэн кран, кранбалка, автокранаар өргөх зөөх ажил гүйцэтгэхдээ эрх бүхий байгууллагад ээлжит шалгалт өгсөн, мэргэжлийн үнэмлэхтэй оосорлогч, дохиочныг ажиллуулна.

3.7. Цахилгааны схем зөөврийн болон байнгын гэрэлтүүлгийг холбох, таслуулах, шилжүүлэх тохиолдолд захиалагчийн шуурхай ажиллагааны хүмүүст захиалга өгч мэргэжлийн хүнээр гүйцэтгүүлнэ.

3.8. Гагнуур хийх, галтай ажил гүйцэтгэх үед ажлын байрыг станцын галын постын эрх бүхий хүмүүст үзүүлж зөвшөөрөл авч нарыдаар орно.

3.9. Гүйцэтгэгч нь өндөрт ажиллах, суваг шуудуу, худаг дотор ажиллах, битүү саван дотор ажиллах, галтай ажиллах, өргөх зөөх механизмтай ажлуудад аюулгүйн нэмэлт арга хэмжээнүүдийг дүрмийн шаардлагад нийцүүлэн авах үүрэгтэй.

3.10. Худаг, суваг, шуудуу, камерт ажил гүйцэтгэхдээ дууссаны дараа тэрчилэн засварлагааны үед заавал таглаж байх. Унаж гэмтэхээс сэргийлж хаалт хашилт тавина.

3.11. Засварын дараа бак, шугам хоолойг усаар дүүргэх, усан шахалт туршилт хийхдээ зөвхөн захиалагчийн цех, нэгжийн эрх бүхий хүмүүсийг байлцуулан гүйцэтгэнэ.

3.12. Гүйцэтгэгч ажил хийж буй зангилаа нэг бүрийг хэсэгчлэн актаар хүлээлгэж өгөх ба тоноглолын задаргаа хийх бүрд тухайн цех, хэсгийн хяналтын инженерүүдэд үзүүлэн акт бүрдүүлэн тэдний зөвшөөрлөөр хаана.

3.5. Засварын баталгаат хугацаанд гэрээт ажлын хөлсний 10%-ийг захиалагчийн дансанд байршуулна.

ДӨРӨВ. ГЭРЭЭ ДҮГНЭЖ ХАРИУЦЛАГА ТООЦОХ

4.1 “ТРДН-40000кВа-н трансформаторт их засвар хийх” ажлыг бүрэн дуусгаж техникийн бичиг баримт бүрдэлтийг хийж захиалагч талд хүлээлгэн өгч гэрээг дүгнэнэ.

4.2. Гүйцэтгэгчийн буруугаас засварын ажлын хугацаа хэтэрвэл гүйцэтгээгүй үүргийн дүнгийн 0.3 хувиар хоног тутам гүйцэтгэгч алданги хүлээх ба уг алданги нийт гэрээний үнийн дүнгийн 30 хувиас хэтрэхгүй байна.

4.3. Захиалагчийн буруугаас төлбөр төлөх хугацаа хэтэрвэл гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.3 хувиар хоног тутам алданги хүлээх ба нийт үнийн дүнгийн 30 хувиас хэтрэхгүй байна.

ТАВ. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

5.1. Давагдашгүй хүчин зүйлд байгалийн гамшиг, гал түймэр, үер, шуурга, газар хөдлөлт, дайн, эдийн засгийн болон импортын шууд хориг, энэ гэрээг баталсны дараа үүсч болзошгүй онцгой байдалд хүргэсэн бусад нөхцлүүд гэрээг биелүүлэхэд саад учруулсан зүйлүүд орно.

5.2. Давагдашгүй хүчин зүйлийн улмаас шууд шалтгаалан энэ гэрээгээр хүлээсэн үүргээ хэсэгчлэн буюу бүхлээр нь биелүүлэхгүйд хүрсэн бол талууд хариуцлагыг хүлээхгүй.

5.3. Давагдашгүй хүчин зүйл үүссэнээс хойш 7 хоногийн дотор гэрээний үүргээ биелүүлэх бололцоогүй болсон тал нь нөгөө талдаа албан бичгээр мэдэгдэнэ.

5.4. Хэрэв давагдашгүй хүчин зүйлс гэрээний биелэлтэнд 1 сарын турш үйлчлэх тохиолдолд үүргээ биелүүлж чадахгүй болсон тал цаашид энэ гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүй татгалзах эрхтэй. Энэ тохиолдолд талууд гэрээг хүчингүй болсон хугацаагаар ажлын гүйцэтгэлийн тооцоог дуусгана.

ЗУРГАА. БУСАД ЗҮЙЛ

6.1. Талууд аль нэгнийхээ зөвшөөрөлгүйгээр энэхүү гэрээг гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

6.2. Гэрээг монгол хэл дээр 4 хувь үйлдэж гүйцэтгэгч нэг хувь, захиалагч гурван хувийг авах бөгөөд хувиуд нь ижил тэгш хүчинтэй.

6.3. Талууд аль нэг нь гэрээтэй холбогдох мэдээлэл солилцох тохиолдолд мэдээллийг авсан тал хуанлийн 7 хоногт багтаан нөгөө талдаа тавьсан асуудлаар тодорхой хариу өгнө.

6.4. Энэхүү гэрээнд шууд заагаагүй бусад аливаа асуудлыг Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөж буй хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

6.5. Талуудын санал зөрөөтэй асуудлаар зөвшилцөлд хүрч чадахгүй бол шүүхээр шийдвэрлүүлнэ.

6.6. Шүүхийн шийдвэр нь эцсийн бөгөөд талууд түүнийг заавал биелүүлнэ.

6.7. Гэрээнд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд үндсэн гэрээний салшгүй хэсэг байна.

6.8. Гэрээнд хоёр тал гарын үсэг зурсан өдрөөс эхэлж хүчин төгөлдөр болно.

ДОЛОО. ТАЛУУДЫН ХАЯГ:

ЗАХИАЛАГЧИЙН ХАЯГ:

Хаяг: Хан-Уул дүүрэг, 3-р хороо
“ДЦС-3” ТӨХК-ийн байр
Утас: 11-343024

ГҮЙЦЭТГЭГЧИЙН ХАЯГ:

..... дүүрэг,-р хороо
.....
РД:

Утас:

Банк:

Данс:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

“ДЦС-3” ТӨХК-ийн Тэргүүн дэд
захирал, ерөнхий инженер

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

“.....” ХХК-ийн
инженер

.....

ЗХА –ны дарга

СБХ –ийн дарга

Ерөнхий нягтлан бодогч

ӨДТ цехийн дарга

Гэрээний мэргэжилтэн

Хянасан: Хуулийн мэргэжилтэн